



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/233

Мөрөн сум

Газрын талбайн хэмжээнд өөрчлөлт  
оруулж, эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын саналыг үндэслэн 2 иргэний гаргасан хүсэлтийн дагуу 0.1586га (0.1586м<sup>2</sup>) газрын газар эзэмшүүлсэн аймгийн Засаг даргын холбогдох захирамжид хавсралтад дурдсанаар газрын талбайн хэмжээнд өөрчлөлт оруулж, эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэнтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.


4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр)-т тус тус үүрэг болгосугай

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 07 дугаар  
сарын 18-ны өдрийн А/233 дугаар  
захирамжийн хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨХ  
ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

№	Иргэндийн овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын байршил	Өөрчилж, нэмэлт оруулж буй захирамжийн багана	Тайлбар
1	Хар дархад, овгийн Жамъян Наранчулуун /РЮ57031501/	6712008634	7-р баг 11-12 тоот	Аймгийн Засаг даргын 2012.07.20-ны өдрийн А/229 дүгээр захирамжийн хавсралтын 29 дэх заалтын 7 дахь баганын "500м <sup>2</sup> " гэснийг "798м <sup>2</sup> " гэж	Газрын талбайн хэмжээ өөрчлөх /хэмжилтээр/
2	Боржигон овгийн Дашдамба Амараа /РЭ66011413/	6712017402	13-р баг Бүрэнхаан сургуулийн зүүн талд	Аймгийн Засаг даргын 2010.05.28-ны өдрийн А/205 дугаар захирамжийн хавсралтын 18 дахь заалтын 6 дахь баганын "600м <sup>2</sup> " гэснийг "788м <sup>2</sup> " гэж	Газрын талбайн хэмжээ өөрчлөх /хэмжилтээр/

Нийт талбайн хэмжээ-1586м<sup>2</sup>

-----oOo-----